

“ХҮННҮ ЭЙР” ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ БОЛОН АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ ХООРОНД БАЙГУУЛСАН ХАРИЛЦАН ОЙЛГОЛЦЛЫН САНАМЖ БИЧИГ

2025 оны 10 сар 10 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “Хүннү Эйр” хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “Компани” гэх/ нөгөө талаас Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /цаашид “Алба” гэх/ хамтран ажиллах талаар дор дурьдсан асуудлаар харилцан тохиролцож энэхүү санамж бичгийг байгуулав.

НЭГ. ЗОРИЛГО

1.1. Санамж бичгийн зорилго нь Иргэний нисэхийн олон улсын байгууллага, Чикагогийн Конвенцийн Хавсралт 13-ын хүрээнд нислэгийн аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх зорилгоор агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийг шинжлэн шалгах үйл ажиллагааг үр дүнтэй, хурдан шуурхай хэрэгжүүлэхэд харилцан дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.2. Санамж бичиг нь агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаа нь хэн нэгнийг буруутгах, хариуцлага тооцоход чиглэгдэхгүй бөгөөд энэ төрлийн осол, зөрчлөөс урьдчилах сэргийлэх, нислэгийн аюулгүй байдлыг бүх түвшинд сайжруулах зорилготой гэдэгт талууд санал нэг байна.

ХОЁР. ХАМТЫН АЖИЛЛАГАА

2.1. Агаарын хөлгөөр тээвэрлэх тухай.

- Агаарын хөлгийн осол, зөрчил болсон газарт шинжлэн шалгах албанаас томилогдсон багийг ачаа тээшийн хамт агаарын хөлгөөр тээвэрлэх ажлыг Компани зохион байгуулж дэмжлэг үзүүлэх.

2.2. Нотлох баримтыг хадгалах, хамгаалах тухай.

- Осол, зөрчлийн газраас ирсэн агаарын хөлөг, түүний эд анги, нотлох баримтыг шинжлэн шалгах ажиллагаа дуустал нууцлалтай хадгалах, хамгаалах боломжоор хангах, шинжилгээнд явуулах, тээвэрлэх, ажиллагааг талууд хамтран шийдвэрлэнэ.

Үүнд:

Компани нь:

- Агаарын хөлгийн осол, ноцтой зөрчлийн үеийн бүхээгийн ярианы, нислэгийн өгөгдлийн болон бусад бичлэг, осол, зөрчилтэй холбоотой байж болзошгүй нислэг техникийн бичиг баримт, нотлох баримтыг цаг алдалгүй хамгаалалтанд авах.
- Осол, ноцтой зөрчилд өртсөн агаарын хөлөг болон түүний том оврын эд анги, нотлох баримтыг ангар болон тусгайлан хадгалах өрөөнд хадгалж хамгаалах.
- Ангар болон тусгайлан гаргасан өрөөнд шинжлэн шалгах албаны шинжлэн шалгагч нарыг нэвтрүүлэх.
- Тусгайлан гаргасан өрөөнд нууцлалын код болон бусад нэвтрэх боломжоор хангаж өгөх.
- Албаны хүсэлтийн дагуу техникийн сорилын болон хэмжих багаж хэрэгслийг ашиглахад дэмжлэг үзүүлэх.
- Хэрэв ангар болон тусгайлан гаргасан өрөөнд гал түймэр, цахилгаан, үер усны болон бусад аюулын эрсдэл үүссэн тохиолдолд Албанд яаралтай мэдэгдэж нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах.

Алба нь:

- Осол, ноцтой зөрчилд өртсөн агаарын хөлөг түүний том оврын эд анги, нотлох баримтыг хадгалах хамгаалуулах талаар урьдчилан компанид мэдэгдэж баталгаажуулах.
- Шинжлэн шалгагч нар ангар болон хадгалалтын өрөө рүү нэвтрэхдээ компанид урьдчилан мэдэгдэх.
- Ангарт байрлуулсан агаарын хөлөг болон тусгайлан гаргасан өрөөнд нууцлалын код болон бусад эрхээр нэвтрэх.
- Шинжлэн шалгах ажиллагааны явцын болон дуусгавар болох үед нотлох баримтыг холбогдох байгууллагад шилжүүлэх шийдвэрийг гаргах.
- Хэрэв ангар болон тусгайлан гаргасан өрөөнд гал түймэр, цахилгаан, үер усны болон бусад аюулын эрсдэл үүссэн тохиолдолд нүүлгэн шилжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах.

2.3 Нөөц шинжлэн шалгагч

- Алба нь Чикагогийн конвенцийн Хавсралт 13, Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах дүрмийн хүрээнд шаардлагатай тохиолдолд шинжлэн шалгах ажиллагаанд нөөц шинжлэн шалгагчийг татан оролцуулж болно.
- Шинжлэн шалгах хамтын ажиллагааны үед нөөц шинжлэн шалгагч нь хууль, дүрмийн дагуу ажил үүргийн хүрээнд харилцан итгэлцэл, албан ёсны үүрэгт захирагдах ёстойг хүлээн зөвшөөрөх.

- Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах ажиллагаанд томилогдсон нөөц шинжлэн шалгагч нь ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх.
- Шинжлэн шалгах үйл ажиллагааны үед нөөц шинжлэн шалгагч осол, ноцтой зөрчил, зөрчилтэй холбоотой аливаа мэдээллийн нууцлалыг шинжлэн шалгах ажиллагаа эцэслэн дуусах хүртэл хугацаанд хадгалах үүрэгтэй.
- Шинжлэн шалгах ажиллагаанд оролцож санал бодлоо илэрхийлсэн, осол, зөрчлийн талаар мэдээлэл өгсөн аливаа этгээдийг буруутгахгүй гэдэгт талууд санал нийлнэ.

2.4 Харилцан мэдээлэл солилцох

- Агаарын хөлгийн осол, зөрчлийн мэдээллийг хууль, дүрэмд заасны дагуу талууд бие биендээ мэдэгдэх.
- Алба нь шаардлагатай тохиолдолд аюулгүй ажиллагааны зөвлөмж, холбогдох мэдээллээр хангах.
- Агаарын хөлгийн нислэгийн аюулгүй байдлыг хангах, сайжруулахтай холбоотой шинэ техник технологийн талаар мэдээлэл солилцох.
- Олон улсад гарч байгаа осол, зөрчлийн талаар мэдээлэл солилцох.

ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАА

3.1 Харилцан ойлголцлын санамж бичгийн талаар “Хүннү Эйр” ХХК-ийн талаас харилцах албан тушаалтан, хаяг, утас, цахим шуудан:

ДУГАР БАТПҮРЭВ

Утас: (976) - 99102271 operation phone /Аюулгүй ажиллагаа хариуцсан захирал бөгөөд НАБАХА-ны дарга /

Цахим шуудан: batpurev@hunnair.com

3.2 Харилцан ойлголцлын санамж бичгийн талаар Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах албаны талаас харилцах албан тушаалтан, хаяг, утас, цахим шуудан:

ЧИМЭДДОРЖ ШИНЭБАЯР

Шинжлэн шалгагч

Буянт-Ухаа, ХУД 21-р хороо, Улаанбаатар хот 17120

Утас: (976-71) 285552, 99162519


Цахим шуудан: shinebayar@aaib.gov.mn

ДӨРӨВ. ЗАРДАЛ ШИЙДВЭРЛЭХ

- 4.1 Харилцан ойлголцох санамж бичгийн 2.1 дэх заалтыг тээвэрлэлтийн дараа холбогдох үнэ тарифийн дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ.
- 4.2 Харилцан ойлголцох санамж бичгийн 2.2 дахь заалтыг ангар болон тусгайлсан өрөө ашигласан, эд мөрийн баримтыг хадгалж хамгаалсан зардлыг харилцан тохиролцож шийдвэрлэнэ.
- 4.3 Харилцан ойлголцох санамж бичгийн 2.1, 2.2 дахь заалтаас бусад нь үнэ төлбөргүй байна.

ТАВ. САНАМЖ БИЧГИЙН ХУГАЦАА

- 5.1. Энэхүү санамж бичиг нь гарын үсэг зурснаас хойш гурван жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.2. Энэхүү санамж бичгийг цуцлах эсхүл нэмэлт өөрчлөлт оруулах тухайгаа аль нэг тал нь нөгөө талдаа хуанлийн 30 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.

Батлав.
АГААРЫН ХӨЛГИЙН ОСОЛ,
ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН
ШАЛГАХ АЛБАНЫ ДАРГА

8112738 ШТЖ1492 9025011078
Ж.ЦОЛМОН

Батлав.
“ХҮННҮ ЭЙР” ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

ХҮННҮ ЭЙР ХХК
УЛААНБААТАР ХОТ
9025040333 ул. 5514339
П.МӨНХЖАРГАЛ